12.7	МУТХУБ-2030-ын 2.1.2, Зорилт 1, ЗГУАХ-ийн 3.2.44, 3.2.47 дахь заалт	ЮНЕСКО-ийн дэлхийн өвийн бүртгэлд бүртгэгдсэн Монгол Улсын соёлын өвийг хамгаалах, Бурхан Халдун уулын соёлын өвийн менежментийн захиргааг байгуулах	Шинээр байгуулах менежментийн захиргааны тоо	1	-	БШШУСЯ
Зорилт 13. Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг өргөжүүлнэ.						
13.1	МУТХУБ-2030-ын 2.2.3, Зорилт 5, ЗГУАХ-ийн 3.2.19, 3.2.30 дахь заалт	Шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлж, судалгаа боловсруулалтын ажлын эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	Технологи бүтээгдэхүүний загварын тоо	300	38.4 Улсын төсөв	БШШУСЯ
13.2	МУТХУБ-2030-ын 2.2.3, Зорилт 5, ЗГУАХ-ийн 3.2.29 дэх заалт	"Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II"-ийг боловсруулж, инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тогтоох	Батлагдсан хөтөлбөрийн тоо	1	-	БШШУСЯ
13.3	МУТХУБ-2030-ын 2.3.3, Зорилт 2, ЗГУАХ-ийн 4.1, 4.3 дэх заалт	Ботаникийн цэцэрлэгийг тохижуулах, байгалийн ургамлын үндэсний генобанканд шаардлагатай барилгыг барих	Ботаникийн цэцэрлэгийн тохижилтын ажлын гүйцэтгэл, хувилар	100	1.0 Улсын төсөв	БОАЖЯ
			Байгалийн ургамлын үндэсний генобанкны барилгын ажлын гүйцэтгэл	100	7.0 Улсын төсөв	БОАЖЯ
13.4	МУТХУБ-2030-ын 2.3.3, Зорилт 5, ЗГУАХ-ийн 3.2.33 дахь заалт	Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэн, төвүүдийн техник, тоног төхөөрөмж, компьютерийг шинэчлэн нийлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувилар	100	0.6 Улсын төсөв	БШШУСЯ



Зорилт 14.Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, шуурхай байдлыг хангана.						
14.1	ЗГУАХ-ийн 5.2.10 дахь заалт	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим сумдад төрийн цахим үйлчилгээний Хур системийг нэвтрүүлэх	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх төв	257	17.0 Улсын төсөв	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар /цаашид ХХМТГ гэх/
14.2	ЗГУАХ-ийн 5.1.18 дахь заалт	Алслагдсан сумдыг өргөн зурвасын шилэн кабелийн сүлжээнд холбох	Шилэн кабелийн сүлжээнд холбогдох сүм	3	1.8 Улсын төсөв	ХХМТГ
14.3	МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 7, ЗГУАХ-ийн 5.1.17, 5.2.8, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын 3.9.3 дахь заалт	Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн системийг хөгжүүлэх	Цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний нэр төрөл Нэгдсэн системд нэвтрүүлсэн төрийн байгууллагын тоо	100 15-аас багагүй	-	ХХМТГ
14.4	ЗГУАХ-ийн 3.2.40 дэх заалт	Хиймэл дагуулын болон газрын сүлжээний радио давтамжийн автоматжуулсан систем нэвтрүүлэх	Шинээр нэвтрүүлэх систем	1	-	ХХМТГ
Зорилт 15.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийг нэмэгдүүлнэ.						
15.1	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого /цаашид "ЭМТББ" гэх/-ын 2.4.2.10, 2.4.10.11, ЗГУАХ-ийн 3.1.2, 3.1.13 дахь заалт	Зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх	Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдашлын хувь Явуулын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа алслагдсан сум, дүүргийн эрүүл мэндийн төвийн тоо Амны хөндийн үзлэг, шүдний өвчний эмчилгээнд хамрагдсан 2-12 насны хүүхдийн хувь	25.0 20 25.0	4.7 Улсын төсөв 23.9 Эрүүл мэндийн даатгалын сан /цаашид ЭМДС гэх/	Эрүүл мэндийн яам /цаашид "ЭМЯ" гэх/

15.2	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 2, ТЭМТББ-ын 2.4.1.8, ЗГҮАХ-ийн 3.1.8, 3.15.10 дахь заалт	Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах	Шинээр ашиглалтад оруулах хүүхдийн эмнэлгийн тоо	6	ЭМЯ
				100.0	
15.3	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 3, ТЭМТББ-ын 2.4.1.11, 2.4.2.12, ЗГҮАХ-ийн 3.1.10.7 дахь заалт	Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа зурх судас, хорт хавдар, бөөр түүнтэй холбоотой хүндрэлээс Үүдэлтэй нас баралтыг бууруулах	Харвалт шигдээсийн нэгж байгуулах эмнэлгийн тоо	7	ЭМЯ
				100.0	
15.4	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 4, ТЭМТББ-ын 2.4.1.11, 2.4.2.12, ЗГҮАХ-ийн 3.1.10.7 дахь заалт	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх	Улирлын томуугийн эсрэг вакцинжуулалтад хамрагдах хүн амын эзлэх хувь	40.0	ЭМЯ
				УБ хот, 5 аймаг	
			Эмнэлгийн мөргөжилтний элэгний В вирусын эсрэг дархлаажуулалтад хамруулах хувь	100.0	

15.5	МУТХУБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.2, 2.4.3, 2.4.4, 3, 3.1.16.2, 3.1.17.1, 3.3.20.4 дэх заалт	Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх	Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, протезийн нэр төрөл, хэмжээний есөлт, хувиар ЭМДС-гаас санхүүжиж байгаа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хувь	20.0	169.0 ЭМДС	ЭМЯ
				70.0		
15.6	МУТХУБ-2030-ын 2.2.2, Зорилт 3, ТЭМТББ-ын 2.4.3.4, ЗГҮАХ-ийн 5.6.12.6 дахь заалт	Эмч эмнэлгийн мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх, Монгол Улсад одоогоор оношлогч, эмчлэх боломжгүй байгаа өвчнийг дотооддоо оношилж, эмчилдэг болох	Нэн шаардлагатай болон ахмад настанд олгох эмийн хөнгөлөлтийн хувь	80.0	2	ЭМЯ
				4		
			Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс ЭМД-ын сангаас санхүүжиж байгаа тусламж, үйлчилгээний төрөл	20	Улсын төсөв	ЭМЯ
			Магадлан итгэмжлэгдсэн спорт клубын тоо	10		
			Гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцах эмнэлгийн мэргэжилтний тоо	25	0.5 Улсын төсөв	ЭМЯ
			Гадаадад ажиллаж байсан мэргэжлийн ур чадвар бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эх орондоо ажиллуулах			



15.7	МУТХҮБ-2030-ын 2.2.2, Зорилт 1, ТЭМТББ-ын 2.4.3.2, 2.4.8.3, ЗГҮАХ-ийн 3.1.16.7, 3.1.15.1, 3.1.15.2 дахь заалт	Эрүүл мэндийн салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Шинээр ашиглалтад орох эмнэлгийн тоо Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	31	62.7 Улсын төсөв	ЭМЯ
				100.0		
Зорилт 16. Нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.						
16.1	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2	Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэх, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжүүлэх	Хамрагдах хүний тоо	60.0 мянга	35.0 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан Цаашид "ХЭДС" гэх/	ХНХЯ
			Шинээр бий болгох ажлын байрын тоо	10 000 байнгын, 15 000 түр ажлын байр		
16.2	МУТХҮБ-2030-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.17 дахь заалт	Бичил аж ахуйн нэгж, иргэдэд Итгэлийн зээлийг олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ арга хэлбэрийн туршилтын хэрэгжилт, хувиар	100.0	10.0 Гадаад эх үүсвэр	ХНХЯ
			Зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо	2000		
16.3	ЗГҮАХ-ийн 3.3.6 дахь заалт	Монгол залуусаа сургаж, дэдлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авах ажиллагчдын тоог бууруулах	Гадаадаас авах ажиллагчдын тоог бууруулах хувь	50.0 хүртэл	-	ХНХЯ
16.4	ЗГҮАХ-ийн 3.3.23 дахь заалт	Инфляцийн түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ
16.5	ЗГҮАХ-ийн 3.4.3, 3.4.4, 3.3.28 дахь заалт	Хүүхдийн хөгжил, хамгаалал, өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх	Боловсруулах хөтөлбөрийн тоо	1	-	ХНХЯ
			Хэрэгжүүлэх хөтөлбөрийн тоо	2		

16.6	МУГУХУБ-2030-ын 2.2.1, Зорилт 3, ЗГУАХ-ийн 3.3.17, 3.3.18 дахь заалт	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчлэх болон нийгмийн халамжийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	2	-	ХНХЯ
16.7	ЗГУАХ-ийн 3.3.23 дахь заалт	Инфляцийн түвшинтэй уялдуулан Нийгмийн даатгалын сан болон Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХНХЯ
16.8	ЗГУАХ-ийн 3.4.9 дэх заалт	Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежид элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлж, төгсөгчдөд мэргэжил, үр чадварыг эзэмшүүлэн, суралцагчдад тэтгэлгийг сэр бүр олгох	Мэргэжил, үр чадвар эзэмшүүлэх төгсөгчдийн тоо, мянга	20	39.5 Улсын төсөв	ХНХЯ
ТАВ. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО						
Зорилт 17. Цагдаагийн байгууллагын мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөрхүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.						
17.1	ЗГУАХ-ийн 5.4.5 дахь заалт	Цагдаагийн байгууллагын хэт богино долгионы радио холбоог шинэчилж, мэдээ, мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	10.0 Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн яам /цаашид "ХЗДХЯ" гэх/
17.2	ЗГУАХ-ийн 5.4.1 дэх заалт	Дотоодын цэргийн хугацаат цэргийн албан хаагчдын нормын хангалтыг хийх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	4.5 Улсын төсөв	ХЗДХЯ
17.3	ЗГУАХ-ийн 5.4.5 дахь заалт	Цагдаагийн байгууллагын автопарк шинэчлэл хийх	Улаанбаатар хотын хүрээний хөдөлгөөнт эргүүлгийн автомашины хангалт, хувиар	100.0	5.0 Улсын төсөв	ХЗДХЯ
17.4	ЗГУАХ-ийн 5.4.13 дахь заалт	Хилийн салбарын парк шинэчлэлийг хийх	Нийт автотехникийн шинэчлэгдэх хувь	18.0	2.0 Улсын төсөв	ХЗДХЯ

17.5	ЗГУАХ-ийн 5.4.13 дахь заалт	Хил хамгаалах байгууллагын барилга байгууламжийг сайжруулах	Шинээр барих барилга байгууламжийн тоо	2	6.5 Улсын төсөв	ХЭДХЯ
17.6	ЗГУАХ-ийн 5.4.14 дэх заалт	Хилийн салбаруудыг радио станцаар хангах	Хэт богино болон богино долгионы радио станцаар хангах нэгжийн тоо	1386 нэгж	1.0 Улсын төсөв	ХЭДХЯ
17.7	ЗГУАХ-ийн 5.2.8, 5.2.9, 5.2.10 дахь заалт	Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээний цогцолбор төв байгуулах	"Нэг иргэн- нэг бүртгэл" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30.0	7.0 Улсын төсөв	ХЭДХЯ
17.8	Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.а дахь заалт, Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.3.3.3 дахь заалт	Хүн ам, орон сууцны улсын тооллогыг явуулж, үр дүнд үндэслэн дэлгэрэнгүй судалгаа хийх, нийтэд тархах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	4.8 Улсын төсөв	Үндэсний статистикийн хороо
17.9	ЗГУАХ-ийн 5.2.8 дахь заалт	Үндэсний гадаад паспортод бичилт хийх, програм хангамж тоног төхөөрөмж нийлүүлэх	Гадаад паспортын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэлт, усралтын ажлын гүйцэтгэл, хувиар	100.0	2.5 Улсын төсөв	ХЭДХЯ
17.10	ЗГУАХ-ийн 5.2.8, 5.2.9, 5.2.10 дахь заалт	Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулах бэлтгэлийг хангаж, техник хэрэгслээр хангах	Сонгуулийн техник хэрэгслэлийн хангалт, хувиар	100.0	7.5 Улсын төсөв	ХЭДХЯ

17.11	ЗГҮАХ-ийн 5.4.7 дахь заалт	Шүүхийн шинжилгээний байгууллагын дижитал судлалын шинжилгээний чадавхыг сайжруулах	Шүүхийн шинжилгээний байгууллагын дижитал судлалын шинжилгээний чадавхыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	18.5 Гадаад эх үүсвэр	ХЗДХЯ
17.12	ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт	Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програмыг хангамжийг нэвтрүүлэх	Визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програмыг хангамжийг нэвтрүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗДХЯ
17.13	ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт	"ISM" системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд "APIS буюу APP" системийг холбож, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх	"ISM" системийн өргөтгөл, сайжруулалтын хүрээнд "APIS буюу APP" системийг холбож, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗДХЯ
17.14	ЗГҮАХ-ийн 5.3.12 дахь заалт	Гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгүүдийн бүрдлийг цахим хэлбэрээр бүрдүүлэх боломж бүхий төрийн байгууллагуудын хооронд холбосон дэд бүтэц, системийг бий болгох	Гадаадын иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах баримт бичгүүдийн бүрдлийг цахим хэлбэрээр бүрдүүлэх боломж бүхий төрийн байгууллагуудын хооронд холбосон дэд бүтэц, системийг бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗДХЯ
17.15	ЗГҮАХ-ийн 3.2.18, 3.2.19 дэх заалт	Их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн чадавхыг нэмэгдүүлж, сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололт, төрийн бодлоготой уялдуулан, багш судлаач, албан хаагч, сонсогчдын чадавхыг нэмэгдүүлэх	Их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн чадавхыг нэмэгдүүлж, сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн ололт, төрийн бодлоготой уялдуулан, багш судлаач, албан хаагч, сонсогчдын чадавхыг нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ХЗДХЯ
17.16	ЗГҮАХ-ийн 5.4.11 дэх заалт	Төрийн архивуудын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх	Төрийн архивуудын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх	Цахим хэлбэрт шилжүүлэх хадгаламжийн нэгжийн тоо	55 мянга гаруй хадгаламжийн нэгж	1.0 Улсын төсөв	ХЗДХЯ
17.17	МУТУБ-2030-ын 2.2 дахь заалт	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмчилгээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эмчилгээний тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Гэмтлийн дараах эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтын хувь	100.0	1.4 Улсын төсөв	ХЗДХЯ

17.18	ЗГҮАХХАХТ-ний 5.1.16, 5.3.5.12 дахь заалт	Прокурорын байгууллагын боловсон хүчнийг чадавхыг сайжруулах, барилга, конторын их засвар, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	12.0 Улсын төсөв,	Улсын ерөнхий прокурорын газар
17.19	МУТХҮБ-2030-ын 2.4, Зорилт 2	Сонгуулийн санал тооллогын техник хэрэгслийг шинэчлэх арга хэмжээг авах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-	Сонгуулийн ерөнхий хороо
Зорилт 18.Үндэсний стандартын тоог нэмэгдүүлж, стандарт, хэмжил зүй, мэргэжлийн хяналтын орон нутгийн чадавхыг сайжруулна.						
18.1	МУТХҮБ-2030-ын 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.5, 2.1.7 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.7 дахь заалт	Монгол Улсын үндэсний стандартыг боловсруулж батлуулах стандарт нутгийн стандартын байгууллагын чадавхыг бэхжүүлэх	Шинээр боловсруулж батлуулах стандарт Шинээр ашиглалтад орох барилга	5 1	0.4 Улсын төсөв	Стандарт, хэмжил зүйн газар
18.2	МУТХҮБ-2030-ын 2.1.7, Зорилт 1, ЗГҮАХХАХТ-ний 2.18, 2.23 дахь заалт	Орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын чадавхыг бэхжүүлэх	Шинээр ашиглалтад орох барилга	2	2.4 Улсын төсөв	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Зорилт 19.Хил орчмын дэд бүтцийг хөгжүүлж, хөрш орнуудтай хийх худалдааг өргөжүүлнэ.						
19.1	Гадаад бодлогын үзэл баримтлал /цаашид ГБУБ гэх/- ын 3.21.6 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.6.5, 5.6.7 дахь заалт	Хөрш орнуудтай хийх гадаад худалдааг өргөжүүлэх зорилгоор хил дамнансан эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг эрчимжүүлэх	Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах ажлын явц, хувиар	100.0	0.2 Улсын төсөв	Шадар сайдын ажлын алба, Гадаад харилцааны яам /цаашид ГХЯ гэх/
19.2	ГБУБ-ын 2.14.1 дэх заалт, ЗГҮАХ-ийн 5.6.2 дахь заалт	Монгол Улс-ОХУ-БНХАУ-ын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх Хөрөнгө оруулалт, зураг төслийн хамтарсан төвийг байгуулах ажлыг эрчимжүүлэх	Төв байгуулах ажлын явц, хувиар	30.0	-	ГХЯ
19.3	ГБУБ-ын 6.27.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.3.12, 5.6.9 дэх заалт	Хилийн чанад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	Цахим хэлбэрт шилжүүлэх консулын үйлчилгээ	6	-	ГХЯ

19.4	ЗГУАХ-ийн 5.6.8 дахь заалт	"Монгол экспорт" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	ГХЯ
Зорилт 20.Энхийг сахиулах ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, барилгын засвар төслийг үргэлжлүүлнэ.						
20.1	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГУАХ-ийн 5.5.2 дахь заалт	Зэвсэгт хүчний хээрийн хөдөлгөөнт холбооны зангилааг шинэчлэх, хээрийн удирдлагын байруудад сансрын холбооны бага оврын станцуудыг суурилуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	1.9 ЗХХС	Батлан хамгаалах яам /цаашид БХЯ гэх/
20.2	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГУАХ-ийн 5.5.2 дахь заалт	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбох	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	70.0	1.6 ЗХХС	БХЯ
20.3	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГУАХ-ийн 5.5.5 дахь заалт	НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	2.0 ЗХХС	БХЯ
20.4	МУТХҮБ-2030-ын 2.4, ЗГУАХ-ийн 5.5.6 дахь заалт	"Барилгын засвар" төслийг хэрэгжүүлж Зэвсэгт хүчний анги, салбаруудын зарим барилга байгууламжийн тохижилт, их засварын ажлыг гүйцэтгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	11.9 ЗХХС	БХЯ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 06 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар
хот

Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан нэр бүхий 17 шүүгч, Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүллсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
120 дугаар зарлигийн хавсралт

1. Б.Цолмонбаатар - Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч;
2. Э.Халиунбаяр - Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч;
3. Ц.Амарсайхан - Улсын дээд шүүхийн шүүгч;
4. Б.Сайханцэцэг - Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч;
5. Д.Цолмон - Улсын дээд шүүхийн шүүгч;
6. Г.Цагаанцоож - Улсын дээд шүүхийн шүүгч;
7. Ж.Оюунтунгалаг - Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч;
8. Д.Дэлгэрцэцэг - Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч;
9. Д.Байгалмаа - Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч;



10. Х.Сонинбаяр - Улсын дээд шүүхийн шүүгч, Иргэний хэргийн танхимын тэргүүн;
11. П.Золзаяа - Улсын дээд шүүхийн шүүгч;
12. С.Амардэлгэр - Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч;
13. Т.Энхжаргал - Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч;
14. Б.Нармандах - Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч;
15. С.Төмөрбат - Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч;
16. Н.Нарантуяа - Багануур дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч;
17. П.Туяат - Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 07 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн шүүгч Сүнжидмаагийн Оюунцэцэгийг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Барилгын тухай хуулийн 6.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАДЕЛХАН

Засгийн газрын 2019 оны 107 дугаар
тогтоолын хавсралт

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, ГАДААДЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НОРМ, ДҮРЭМ, СТАНДАРТЫГ БҮРТГЭХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандарт (цаашид “гадаадын норм, нормативын баримт бичиг” гэх)-ыг бүртгэх, хэрэглэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Барилгын салбарт шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулаагүй харилцааг гадаадын норм, нормативын баримт бичгээр зохицуулах, бүртгэх, хэрэглэхэд энэ журмыг мөрдөнө.

1.3. Олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 12.3-т заасны дагуу Стандартчилал, техникийн

зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэнэ.

1.4. Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулаагүй харилцаанд хэрэглэх гадаадын норм, нормативын баримт бичиг, техникийн зохицуулалт, барилгын норм ба дүрмийн шаардлагад нийцсэн тохиолдолд бүртгэж хэрэглэнэ.

Хоёр. Гадаадын норм, нормативын баримт бичгийг бүртгэх

2.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гадаадын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх хүсэлт гаргахад дор дурдсан материалыг бүрдүүлэн энэ журмын хавсралт 1-д заасан загварын дагуу Барилгын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ:

2.1.1. бүртгүүлж хэрэглэх гадаадын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх болсон шалтгаан, шаардлага, хамрах хүрээ, зориулалт, технологийн зарчим, эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлагыг тусгасан дэлгэрэнгүй танилцуулга;

2.1.2. бүртгүүлж хэрэглэх гадаадын норм, нормативын баримт бичгийг гадаад улсын эрх бүхий байгууллагаас худалдан авсан талаарх албан ёсны баримт;

2.1.3. бүртгүүлж хэрэглэх гадаадын норм, нормативын баримт бичгийн эх хувь, баталгаат орчуулга;

2.1.4. Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын лавлагаа;

2.2. Гадаадын норм, нормативын баримт бичиг нь дор дурдсан ерөнхий шаардлагыг хангасан байна:

2.2.1. Монгол Улсын хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх;

2.2.2. Монгол Улсын барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгээр зохицуулаагүй асуудлыг тусгасан байх;

2.2.3. Монгол Улсын байгаль, цаг уурын нөхцөл, газар хөдлөлт, инженер-геологийн болон бусад онцлогт тохирсон байх;

2.2.4. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, чанар, аюулгүй байдлын болон галын аюулгүй байдал, эрүүл ахуйн заавал мөрдөх шаардлага, зохицуулалттай зөрчилдөхгүй байх;



2.2.5. холбогдох гадаад улсад нийтээр заавал дагаж мөрдөх шинж чанартай байх.

2.3. Энэ журмын 2.1-д заасан байгууллага хүсэлтийг хүлээн авч, 60 хоногийн дотор багтаан дор дурдсан дарааллын дагуу шаардлага хангасан эсэхийг хянаж шийдвэрлэнэ:

2.3.1. салбарын 3-аас доошгүй тооны мэргэшсэн зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэнг томилж, санал дүгнэлт гаргуулна;

2.3.2. салбар дундын зохицуулалттай асуудалд хамаарах гадаадын норм, нормативын баримт бичигт холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авна;

2.3.3. зохих бэлтгэлийг хангуулан холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ;

2.3.4. мэргэжлийн зөвлөлөөс дэмжсэн тохиолдолд салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

2.4. Гадаадын норм, нормативын баримт бичгийг бүртгүүлэхээр гаргасан хүсэлт, холбогдох материал дутуу, шаардлага хангаагүй буюу мэргэжлийн болон салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлөөс дэмжээгүй тохиолдолд зохих журмын дагуу албан бичгээр буцаана.

2.5. Энэ журмын 2.1-д заасан байгууллага гадаадын норм, нормативын баримт бичгийг мэргэжлийн болон салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлөөс дэмжсэн тохиолдолд холбогдох материалын хамт барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Гадаадын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх

3.1. Мэргэжлийн болон салбарын шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлөөр хэлэлцэн дэмжсэн гадаадын норм, нормативын баримт бичгийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр бүртгэх, хэрэглэхийг зөвшөөрч батална.

3.2. Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хэрэглэхийг зөвшөөрч, бүртгэсэн гадаадын норм, нормативын баримт бичгийг хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлснээр хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.

3.3. Энэ журмын 2.1-д заасан байгууллага гадаадын норм, нормативын баримт бичгийн бүртгэлийг энэ журмын хавсралт 2-ын дагуу хөтөлж, зохих журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

3.4. Бүртгэгдсэн гадаадын норм, нормативын баримт бичгийг бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хэрэглэж болно.

3.5. Гадаадын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх хугацааг 2 хүртэлх жилээр тогтооно.

Дөрөв. Бусад

4.1. Тухайн гадаадын норм, нормативын баримт бичиг шинэчлэгдэх, өөрчлөлт орох, хүчингүй болох тохиолдолд энэ журмын 2.1-д заасан байгууллага тухай бүр хүсэлт гаргасан этгээдэд болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасан тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гадаадын норм, нормативын баримт бичгийг энэ журамд заасны дагуу дахин бүртгүүлнэ.

4.3. Гадаадын норм, нормативын баримт бичгийн баталгаат орчуулгын үнэн зөв байдлыг хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хариуцах бөгөөд маргаантай асуудал гарсан тохиолдолд гадаадын норм, нормативын баримт бичгийн эх хувийг баримтална.

Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журмын 1 дүгээр хавсралт

ГАДААДЫН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ ТУХАЙ ХҮСЭЛТ

..... оныдугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

“БАРИЛГЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА”-д

1...../иргэн,аж ахуйн нэгж, байгууллага/ нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй дараахь гадаадын норм, нормативын баримт бичгийг хэрэглэх шаардлагатай байгаа тул бүртгэж хэрэглэх асуудлыг шийдвэрлэж өгнө үү.



Д/д	Аль улсын норм, нормативын баримт бичиг болох	Норм, нормативын баримт бичгийн эх хувийн нэр, дугаар, тэмдэглэгээ	Баталгаат орчуулгын хувь, хуудасны тоо	Хэрэглэх хүрээ	Хугацаа
1	2	3	4	5	6

2. Дээр дурдсан гадаадын норм нормативын баримт бичгийн танилцуулга, эх хувь, холбогдох материал, монгол хэл дээрх албан ёсны баталгаат орчуулгыг хавсаргав.

3. Гадаадын норм нормативын баримт бичгийг хэрэглэх хугацаанд өөрчлөлт орсон тохиолдолд дахин бүртгүүлэх үүргийг хүлээнэ.

.....
/Гарын үсэг, нэр/

.....
/огноо/

Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журмын 2 дугаар хавсралт

ГАДААДЫН НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН БҮРТГЭЛ

Д/д	Хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Бүртгэсэн гадаадын норм, нормативын баримт бичгийн нэр		Бүртгэсэн огноо	Хэрэглэхийг зөвшөөрсөн шийдвэрийн дугаар, огноо	Хэрэглэх хугацаа
		Холбогдох орны хэлээр	Баталгаат орчуулгын нэрээр			

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turii_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2,5

Индекс: 200003